

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн ХАМТАРСАН МЭДЭЭЛЭЛ

Өмнөговь аймаг
Ханбогд сум

2017 оны 07-р сарын 19

Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн (ГТЗ)¹ хурал 2017 оны 07 дугаар сарын 19-нд Иргэдийн хөгжлийн төвд боллоо. Хуралд ГТЗ-ийн гишүүд болох Ханбогд сумын Захиргааны төлөөлөл, Малчдын төлөөлөл болон Оюу толгой компанийн төлөөлөл оролцлоо. Мөн Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газрын (ЭЗНХЗОГ)² чиглүүлэгч гэрээний хэрэгжилтэнд хяналт хийх үүргээ хэрэгжүүлж хуралд ажиглагчаар оролцлоо.

Талууд энэ хурлаар Малчдын гомдлыг барагдуулах хоёр гэрээнд тохирсон ажлын хэрэгжилтийн явцыг хэлэлцлээ. Гэрээнд хавсаргасан Үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөнд зааснаар ажил хариуцсан талууд хэрэгжүүлсэн ажлынхаа явцыг танилцуулсан юм. Цаашдаа хийхээр тохирсон ажил нэг бүрийн хэрэгжилтийн байдлыг улирал бүрийн сүүлийн сарын 25-нд тайлан байдлаар бэлтгэн гаргаж хэлэлцэж байхаар тохиров. Энэ дагуу 9 сарын 25 гэхэд 2017 оны 3-р улирлын тайланг бэлтгэн гаргах болов.

2016 оноос эхлэн Зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, талуудын чадавхийг бэхжүүлэх үүднээс Пийс Нексус байгууллагатай хамтран ажиллаж байгаа билээ. Энэ хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй ажлын явцтай танилцаж, ойрын хугацаанд хэрэгжих сургалт болон бусад ажлын талаар саналаа тохирлоо.

Ханбогд сумын Гурван талт зөвлөл

¹ Ханбогд сумын Сумын удирдлага, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений газраас (ЭЗНХЗОГ) чиглүүлж байна.

² Эрх зүйн Нийцэл Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗНХЗОГ) бол Дэлхийн Банкны Группын Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) болон Олон Талын Хөрөнгө Оруулалтын Баталгааны Агентлагтай (ОТХОБА) холбоотой асуудлаар хөндлөнгийн хараат бус хариуцлагын механизмын үйлчилгээ үзүүлдэг хараат бус, бие даасан байгууллага болно.